



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 473

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн гуравдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Янжмаа/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ

141223366

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03  
дугаар сарын 01 - ны өдрийн 1/25  
дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1	Баянгол дүүрэг, Ангирмаа өрхийн эрүүл мэндийн төв	22/2023	2 жил	2023.03.12	2025.03.12
2	Бриллианс ХХК-ийн Бриллиант эмнэлэг	23/2023	4 жил	2023.03.12	2027.03.12
3	Оргил рашаан сувилал ХХК-ийн сувилал	24/2023	4 жил	2023.03.12	2027.03.12
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв	25/2023	2 жил	2023.03.12	2025.03.12
5	Энэрэлт манал ХХК-ийн эмнэлэг	26/2023	2 жил	2023.03.12	2025.03.12
6	Өвөрхангай аймаг, Асархайрхан эмнэлэг	27/2023	2 жил	2023.03.12	2025.03.12
7	Өвөрхангай аймаг, Баянгол сумын эрүүл мэндийн төв	28/2023	2 жил	2023.07.04	2025.07.04
8	Өвөрхангай аймаг, Сэмжид Хужирт рашаан сувилал	29/2023	4 жил	2023.03.01	2027.03.01
9	Өвөрхангай аймаг, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг	30/2023	3 жил	2023.04.06	2026.04.06
10	Өвөрхангай аймаг, Энэрэл Хархорин өрхийн эрүүл мэндийн төв	31/2023	3 жил	2023.05.17	2026.05.17
11	Увс аймаг, Завхан сумын эрүүл мэндийн төв	32/2023	2 жил	2023.03.31	2025.03.31
12	Увс аймаг, Элбэг өгөөж өрхийн эрүүл мэндийн төв	33/2023	2 жил	2023.03.01	2025.03.01
13	Хөвсгөл аймаг, Дэлгэрмөрөн өрхийн эрүүл мэндийн төв	34/2023	2 жил	2023.03.05	2025.03.05
14	Хөвсгөл аймаг, Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төв	35/2023	2 жил	2023.03.05	2025.03.05
15	Хөвсгөл аймаг, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төв	36/2023	3 жил	2023.03.05	2026.03.05
16	Хөвсгөл аймаг, Улаан-Уул сумын эрүүл мэндийн төв	37/2023	3 жил	2023.03.05	2026.03.05

17	Хөвсгөл аймаг, Цагаан-Уул сумын эрүүл мэндийн төв	38/2023	3 жил	2023.03.05	2026.03.05
18	Хөвсгөл аймаг, Цагаан-Үүр сумын эрүүл мэндийн төв	39/2023	2 жил	2023.03.05	2025.03.05
19	Хөвсгөл аймаг, Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв	40/2023	2 жил	2023.03.05	2025.03.05

ооооо